

DESIGN



ТӨРИЙН ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА

Төрийн албан
хаагчдад тоон
гарын үсгийн
гэрчилгээ олгох
зааварчилгаа

2017 он
Улаанбаатар хот

1. Ерөнхий мэдээлэл

Монгол Улс нь нийтийн түлхүүрийн шаталсан тогтолцоог мөрдөх ба ерөнхий бүтэц, тогтолцоо болон хэрэглээг дараах хууль, бодлогын чиглэл, журмуудаар тодорхойлсон. Үүнд:

- ❖ Цахим гарын үсгийн тухай хууль
 - Монгол Улсын Их Хурал – 2011.12.15
 - Холбоос: <http://crc.gov.mn/k/wV>
- ❖ Монгол Улсад цахим гарын үсгийн талаар төрөөс баримтлах бодлогын чиглэл
 - Мэдээллийн Технологи, Шуудан, Харилцаа Холбооны газрын даргын тушаал – 2015.03.25
 - Холбоос: <https://goo.gl/bYTmA2>
- ❖ Монгол Улсын цахим гарын үсгийн нийтийн түлхүүрийн дэд бүтцийн журмууд
 - Харилцаа Холбооны Зохицуулах Хороо – 2014.09.30
 - Харилцаа Холбооны Зохицуулах Хороо – 2015.07.08 /өөрчлөлт орсон/
 - Холбоос: <http://crc.gov.mn/k/BG>


2. Төрийн гэрчилгээжүүлэх байгууллага /ТГБ/

Харилцаа Холбоо, Мэдээллийн Технологийн газраас 2017 оны 04 сарын 18-ний өдөр ирүүлсэн 1/325 тоот албан бичгийн дагуу буюу Монгол Улсын Засгийн газрын 151 дүгээр тогтоолын 2 дугаар заалт, “Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг ашиглах талаар төрөөс баримтлах бодлогын чиглэл” –ийн 3.8, 5.4 –т тус тус заасны дагуу “Үндэсний дата төв” УТҮГ нь төрийн гэрчилгээжүүлэх байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлж ажиллаж байна.

Төрийн гэрчилгээжүүлэх байгууллага нь “Бүртгэлийн нэгж” /БН/ -ийн үүргийг давхар гүйцэтгэн ажиллах ба төрийн байгууллага бүр бүртгэлийн ажилтан буюу байгууллагыг төлөөлөн БН-тэй харьцах ажилтанг томилон БН-тэй гэрээ байгуулан ажиллана. Мөн төрийн байгууллага нь ТГБ-тай гэрээ байгуулан БН-ийн үйл ажиллагааг явуулж болно.

3. Нийтийн түлхүүрийн дэд бүтцийн тогтолцоо

Зураг 1. Нийтийн түлхүүрийн дэд бүтцийн ажиллагааны ерөнхий бүдүүвч



4. Төрийн албан хаагчдад тоон гарын үсгийн гэрчилгээ олгох заавар

Төрийн гэрчилгээжүүлэх байгууллага нь БН-ийн үүргийг давхар гүйцэтгэн ажиллах ба төрийн байгууллагыг төлөөлсөн бүртгэлийн ажилтантай гэрээ байгуулан ажиллана. Төрийн албан хаагчдын тоон гарын үсгийн гэрчилгээг ТГБ нь үнэгүй олгоно.

❖ Алхам 1.

Төрийн байгууллага нь тоон гарын үсгийн гэрчилгээний тээгч буюу төхөөрөмжийг худалдан авна. ТГБ-н БН-ийн системд бүртгүүлнэ.

/БН-ийн системд бүртгүүлэх: <http://esign.gov.mn> цахим хуудасны ТГБ цэсний бүртгүүлэх сонголтыг сонгоно. Төрийн гэрчилгээжүүлэх байгууллага нь тээгч буюу төхөөрөмжийг худалдаалахгүй./

❖ Алхам 2.

Төрийн байгууллага нь бүртгэлийн ажилтанг томилсон тухай албан бичгийг “Үндэсний дата төв” УТҮГ-т ирүүлэх ба бүртгэлийн ажилтан нь дараах баримт бичгийг бүрдүүлэн төрийн гэрчилгээжүүлэх байгууллагатай “Тоон гарын үсэг олгоход хамтран ажиллах” болон “Тоон гарын үсэг эзэмших” гэрээг байгуулна.

❖ Алхам 3.

Тоон гарын үсэг эзэмших гэрээ байгуулсан бүртгэлийн ажилтанд тоон гарын үсгийг олгох ба тухайн ажилтанд ТГБ-н БН-ийн системд нэвтрэх эрхийг олгоно. Тус системд төрийн байгууллагыг төлөөлж буй бүртгэлийн ажилтан нь өөрийн байгууллагын тоон гарын үсгийн гэрчилгээ авах ажилтнуудын мэдээллийг оруулах ба шаардлагатай баримт бичгийг бүрдүүлнэ. */БН-ийн системд нэвтрэх: <http://esign.gov.mn> цахим хуудасны ТГБ цэсний нэвтрэх сонголтыг сонгоно. /*

❖ Алхам 4.

ТГБ-н БН-ийн системд бүртгүүлсэн төрийн байгууллагын ажилтнуудын мэдээлэл болон бүрдүүлсэн баримт бичгийн дагуу ТГБ-н БН-ийн ажилтан /Үндэсний дата төв УТҮГ/ нь тухайн байгууллагын ажилтнуудад олгогдох тоон гарын үсгийн гэрчилгээг тус байгууллагын бүртгэлийн ажилтанд олгох ба хувийн түлхүүрийн буюу тээгч төхөөрөмжийн нууц үгийг тухайн ажилтны бүртгэлтэй цахим шуудангаар илгээнэ. Төрийн байгууллагын бүртгэлийн ажилтан нь гэрээний дагуу эдгээр тоон гарын үсгийг албан хаагчдадаа олгоно.

5. Бүрдүүлэх баримт бичиг:

Төрийн байгууллагын бүртгэлийн ажилтнаар гэрээ байгуулан ажиллах ажилтан нь 5.1 болон 5.2-д заасан баримт бичгүүдийг бүрдүүлэх ба бусад тоон гэрчилгээ хүсэгч ажилтнууд нь зөвхөн 5.2-д заагдсан баримт бичгүүдийг бүрдүүлнэ.

5.1 Төрийн байгууллагын бүртгэлийн ажилтны бүрдүүлэх баримт бичиг:

- Төрийн байгууллагын албан бичиг */Бүртгэлийн ажилтнаар томилсон тухай/*
- Бүртгэлийн ажилтны “Тоон гарын үсэг олгоход хамтран ажиллах гэрээ”
/Энэхүү гэрээг БН-ийн системд бүртгүүлсний дараа системээс бүртгэгдсэн цахим шуудан руу илгээнэ./

5.2 Төрийн байгууллагын албан хаагч /тоон гарын үсэг эзэмшигч/ -ийн бүрдүүлэх баримт бичиг:

- Тоон гарын үсэг олгох албан хаагчдын жагсаалт бүхий албан бичиг.
Албан бичиг нь дараах мэдээллийг агуулсан байна. Үүнд:
 - Ажилтнуудын нэрсийн жагсаалт
 - Ажилтнуудын регистрийн дугаарын мэдээлэл
 - Ажилтнуудын албан тушаалын мэдээлэл
 - Ажилтнуудын цахим шуудангийн мэдээлэл
- Төрийн албан хаагч бүр:
 - Тоон гарын үсэг эзэмших гэрээ
/ Энэхүү гэрээг <http://esign.gov.mn> цахим хуудасны ТГБ цэсний “Бүрдүүлэх бичиг баримт” хуудаснаас татан авна уу./
 - Тоон гарын үсгийн гэрчилгээ эзэмшихийг хүссэн өргөдөл
/ Энэхүү өргөдлийг <http://esign.gov.mn> цахим хуудасны ТГБ цэсний “Бүрдүүлэх бичиг баримт” хуудаснаас татан авна уу./
 - Иргэний үнэмлэхний хуулбар
 - Ажилд томилсон тушаалын хуулбар

6. Тоон гарын үсгийн гэрчилгээнд хэвлэгдэх мэдээлэл

Төрийн албан хаагчийн тоон гарын үсгийн гэрчилгээнд дараах мэдээллүүд хэвлэгдэнэ.

Үүнд:

- Овог
- Нэр
- Албан тушаал
- Газар, хэлтсийн нэр
- Байгууллагын нэр
- Цахим шуудангийн хаяг /төрийн албан хаагчийн/